



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 10 дугаар
сарын 16 өдөр

Дугаар А.ЭНХ

Улаанбаатар
хот

Нийслэлийн ногоон бүсийн Ойн анги байгуулах тухай

Нэг. Нийслэлийн ногоон бүсэд ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулж хариуцан гүйцэтгэх мэргэжлийн аж ахуй шаардлагатай байгааг харгалзан Монгол улсын Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг үндэслэн Нийслэлийн Байгаль Орчны Хяналтын Газрын дэргэд Ногоон бүсийн Ойн ангийг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн байгуулж аж ахуйн тооцоон дээр ажиллуулсугай.

Хоёр. Нийслэлийн Байгаль орчны хяналтын газрын ойн аж ахуйн арга хэмжээний ажил үүрэг, одоо ажиллаж буй ойн инженерийн орон тоог ногоон бүсийн Ойн ангид шилжүүлэн гүйцэтгүүлсүгэй.

Гурав. Ногоон бүсийн Ойн ангийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М. ЭНХБОЛД



**НИЙСЛЭЛИЙН НОГООН БҮСИЙН
ОЙН АНГИЙН ДҮРЭМ**

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Нийслэлийн ногоон бүсийн ойн анги (цаашид ойн анги гэх) нь ногоон бүсийн ойг хамгаалах зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, түймэр хортонгоос сэргийлэх, ойн сангийн бүтцийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж, хариуцан гүйцэтгэх мэргэжлийн аж ахуйн нэгж мөн.
2. Энэхүү Ойн анги нь Нийслэлийн Байгаль орчны хяналтын газрын дэргэд аж ахуйн тооцоон дээр үйл ажиллагаа явуулна.
3. Ойн анги нь Монгол улсын хууль тогтоомж, Байгаль орчны яам, НИТХ, түүний тэргүүлэгчид, нийслэлийн засаг дарга, түүний тамгын газар, Байгаль орчны хяналтын газрын холбогдох эрхийн акт, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
4. Ойн анги нь аж ахуйн нэгжийн хувьд оорийн данс тооцоотой байх ба тогтоосон журмаар хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Ойн анги нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллана. Үүнд:
 - Дарга
 - Инженер
 - Нягтлан бодогч
 - Техникч
 - Жолооч – механик
 - Нярав – сахиул
 - Түр буюу улиралын ажилчид
2. Ойн анги нь ой цэвэрлэгээний, мод үржүүлгийн зэрэг бригад хэсгийг зохион байгуулан ажиллуулж болно.
3. Ойн ангийн даргыг Нийслэлийн Байгаль орчны хяналтын газрын дарга томилж, чөлөөлөх ба тус газрын зөвлөлийн гишүүн байна.
4. Ойн ангийн тухайн жилийн үйл ажиллагааны зардлыг оны эхэнд НБОХГ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлана.
5. Ойн анги нь эрхэлсэн үүрэг ажил Ойн аж ахуйн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг НБОХГ-ын өмнө бүрэн хариуцаж тайлагнана.
6. Ойн анги нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай машин техник, тоног төхөөрөмж, ажлын багаж, агуулах, хашаа, хүлэмж зэрэг материаллаг баазтай байна. Үүнийг нийслэлийн хөрөнгө оруулалт болон өөрийн үйл ажиллагааны ашигаар бүрдүүлж бэхжүүлнэ.

Гурав. ЭРХЛЭХ АЖИЛ ҮҮРЭГ

1. Ногоон бүсийн ойн арга хэмжээний хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.
2. Ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд доорхи ажлыг гүйцэтгэнэ.
 - а. Ногоон бүсийн ойн сан бүхий газрын шаардлагатай талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг хийх.
 - б. Батлагдсан зураг схемийн дагуу ногоон бүсийн ойд түймэрийн халз, шороон зурвас байгуулах.
 - в. Модны үр боргоцой бэлтгэн боловсруулж ашиглах.
 - г. Ойжуулалтын тарьц, суулгацыг ил талбай ба хүлэмжинд тарьж ургуулах.
 - д. Ногоон бүсийн тогтоосон талбайг шинээр ойжуулах ба нөхөн тарилт хийх.
 - е. Ойн хортон шавьж устгалын ажлыг батлагдсан төслөөр мэргэжлийн байгууллагатай хамтран хийх.
 - ё. Ногоон бүсийн ой зохион байгуулалтыг тогтоосон хугацаанд гүйцэтгүүлж оролцох.
3. Ойн сан бүхий газар, ойжуулсан талбайг хамгаалах хашаа хайс барих ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийнэ.
4. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар тохижилтонд зориулж суулгац бэлтгэн өгөх, мод бут тарих, зүлэгжүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгэнэ.
5. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийн дагуу хураасан мод түлээг татаж тээвэрлэх ажлыг хариуцна.
6. Ногоон бүсэд байнга оршин суудаг айл өрх, байгууллага, аж ахуйн нэгжийн түлээний модны хэрэгцээг тооцох.
7. Бусад аймаг, сум, мод бэлтгэлийн газартай гэрээ байгуулж, түлээ бэлтгэх, нийлүүлэх ажил эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээр дамжуулан нийслэлийн түлээний модны хэрэгцээг хангах арга хэмжээ зохион байгуулан дүнг нэгтгэж тайлагнана.
8. Ойн санг хамгаалах, мод үржүүлэх, ойжуулах, хот цэцэрлэгжүүлэх, аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд оролцоно.
9. Ногоон бүсийн ойн сангийн бүтэц, хамгаалалт, ойн аж ахуйн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг иргэд байгууллагад мэдээлэх, сурталчилах ажлыг хийнэ.

Дөрөв. ЭДЛЭХ ЭРХ

Ойн анги нь үйл ажиллагаа явуулахтай холбогдуулж дараах эрх эдлэнэ. Үүнд:

1. Ногоон бүсийн ойн сантай холбоотой бүх төсөл, арга хэмжээнд дүгнэлт гаргахад санал өгнө.
2. Төлөвлөгөөт ойн аж ахуйн арга хэмжээний зураг төслийг шаардаж бэлэн болгуулан, төсөв хөрөнгийн урдчилгаа авна.
3. Мод үржүүлэх, ойжуулалтын тарьц суулгац ургуулах, үр боргоцой хадгалж боловсруулах болон эх ургамлын плантацийн зориулалттай газрыг төлбөргүйгээр ашиглаж эзэмшинэ.
4. Нийслэлийн ногоон бүсэд багтах тусгай хамгаалалттай газрын ойд авч хэрэгжүүлэх ойн аж ахуйн зарим арга хэмжээг гэрээ байгуулан гүйцэтгэнэ.
5. Ногоон бүсийн ой хамгаалах, ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх, материаллаг баазаа бэхжүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, туслах ажил үйлчилгээ эрхлэх талаар санал хүсэлт, төсөл боловсруулан НБОХГ, БОЯ, Нийслэлийн ЗДТГ-т тавьж шийдвэрлүүлнэ.